



МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Бадамсүрэн/-д даагасугай.

ДАРГА



С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны
зөвлөлийн салбар зөвлөлийн 2021 оны 12 дүгээр сарыг
18-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах нэгж, албан тушаалтан
1.	Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай, төсвийн шууд захирагч менежер болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах	1 дүгээр сард	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг зохих журмын дагуу бүх шатанд байгуулж, баталгаажуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргаа удирдлагын газрын дарга
2.	Яамны төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох саналыг нэгтгэн боловсруулж, шийдвэрлүүлэх	1 дүгээр сард	Журамд заасан шаардлага хангасан албан хаагчид зэрэг дэв бүрэн олгогдсон байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргаа удирдлагын газрын дарга
3.	Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал зөвлөмж гаргах	2 дугаар сард	Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж өгсөн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хяналт-шинжилгээн үнэлгээ, дотоод аудит газрын дарга
4.	Төрийн албаны зөвлөлөөс хийх хүний нөөцийн аудитад бэлтгэл ажлыг хангах, аудитад шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх	1 дүгээр улиралд	ТАЗ-ийн хүний нөөцийн аудитын багт шаардлагатай мэдээллийг гаргаж өгч, холбогдох журмын дагуу бэлтгэл ажлыг хангасан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

5.	Ёс зүйн зөрчлийн болон өргөдөл, гомдол, маргааны мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Хагас, бүтэн жилд	Холбогдох мэдээг журамд заасны дагуу нэгтгэн гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга
6.	Яамны төрийн албан хаагчдын бүртгэл судалгааг хөтөлж, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан болон холбогдох бусад тайлан мэдээг гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Хагас, бүтэн жилд	Яамны төрийн албан хаагчдын мэдээллийг тухай бүр баяжуулж, мэдээллийн санг бүрдүүлсэн байна. Тайлан мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
7.	“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулах албан хаагчийг тодруулж, ТАЗСЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Хагас, бүтэн жил	Газар, хэлтсээс нэр дэвшүүлж, ТАЗСЗ-өөр хэлэлцүүлж, шалгарсан албан хаагчийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж, ТАЗ-д хүргүүлсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
8.	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн батлуулах, түүнийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Жилдээ	Хөтөлбөрийг судалгаанд үндэслэн бодитой, үндэслэлтэй, үр дүнд хүрэх тодорхой зорилт, арга хэмжээг тусган боловсруулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
9.	Яамны албан хаагчдын 2022 оны сургалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах	Жилдээ	Албан хаагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
10.	Яамны хэлтэс, албаны даргын сул орон тоонд тусгай шалгалтыг зохион байгуулж, томилогдох ажилтныг тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн талаарх дүгнэлтийг Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, томилох эрх бүхий этгээдэд санал болгох	Жилдээ	Хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
11.	Ажлын байрны сул орон тоонд тусгай шалгалтыг зохион байгуулж, төрийн албан хаагчдыг томилох, сул орон тоог нээлттэй, ил	Жилдээ	Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн ил тод, нээлттэй байдлыг хангасан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

	тод зарлах зэрэг хүний нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах			
12.	Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Маргаан хянан шийдвэрлэх комисс нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу асуудлыг судлан шийдвэрлэсэн байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит газрын дарга
13.	Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах шаардлагатай албан хаагчдын жагсаалтыг гаргаж, суралцах боломжоор хангах	Жилдээ	Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах шаардлагатай албан хаагчдын судалгааг гаргаж, эрх бүхий сургалтын байгууллагад саналыг хүргүүлж, сургалтад хамруулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
14.	Тус яамны төрийн захиргааны албан хаагчдыг хариуцсан ажлын чиглэлээр туршлагажуулах, удирдамжийн дагуу харьяа байгууллагуудад томилолтоор ажиллуулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Тус яамны төрийн захиргааны албан хаагчдыг хариуцсан ажлын чиглэлээр удирдамжийн дагуу харьяа байгууллагуудад томилолтоор ажиллуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
15.	Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, хамт олны зэрэг уур амьсгалыг бүрдүүлэх чиглэлээр олон нийтийг хамруулсан үйл ажиллагааг зохион байгуулах	Жилдээ	Хамт олны зэрэг уур амьсгалыг бүрдүүлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр олон нийтийг хамарсан тодорхой үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
16.	Төрийн албаны зөвлөлөөс гарсан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	ТАЗ-ийн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
17.	Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх	Жилдээ	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар бодитой арга хэмжээг хэрэгжүүлж, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг бүрэн өгч ажилласан байна.	Салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга

18.	Төрийн албаны зөвлөл болон яамны цахим хуудсаар тус салбар зөвлөлийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй сурталчлах, холбогдох мэдээллийг түүнд байршуулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Яамны албан хаагчид болон бусад хэрэглэгчдэд мэдээллийг нээлттэй, шуурхай хүргэж ажилласан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
19.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааныг бэлтгэл ханган зохион байгуулах	Тухай бүр	Холбогдох журмын дагуу хуралдааны бэлтгэлийг хангаж, зохион байгуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
20.	Төрийн албаны зөвлөлөөс баталсан хөтөлбөр, удирдамж болон Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Тухай бүр	Төрийн албаны зөвлөлөөс баталсан хөтөлбөр, удирдамж болон Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт, сурталчилгааг зохион байгуулсан байна.	ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга
21.	Төрийн албаны зөвлөлөөс баталсан удирдамж, аргачлалын дагуу харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хүний нөөцийн чиглэлээр аудит хийх.	Тухай бүр	Тус яамны харьяа төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх ажлыг зохион байгуулсан байна.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ